

21



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 158

Номгон

**Ой тэмдэглэн өнгөрүүлэх зарим
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, 20.1.14, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тулгар төрийн 2231 жилийн ой, Их Монгол Улс байгуулагдсаны 816 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 111, Ардын хувьсгалын 101 жилийн ой, Баянхонгор аймгийн Богд сумын уугуул Монгол Улсын Арслан Пагамын Аюушийн мэндэлсний 100 жилийн ой, Хэл шинжлэлийн ухааны доктор, профессор Сономын Лувсанвандангийн мэндэлсний 90 жилийн ой, Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний 30 жилийн ой, Баянхонгор аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тэмдэглэх асуудлаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

1.1. Тулгар төрийн 2231 жилийн ой, Их Монгол Улс байгуулагдсаны 816 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 111, Ардын хувьсгалын 101 жилийн ой, Баянхонгор аймгийн Богд сумын уугуул Монгол Улсын Арслан Пагамын Аюушийн мэндэлсний 100 жилийн ой, Хэл шинжлэлийн ухааны доктор, профессор Сономын Лувсанвандангийн мэндэлсний 90 жилийн ой, Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний 30 жилийн ой, Баянхонгор аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тэмдэглэх товыг 2022 оны 07 дугаар сард тогтоох асуудлыг Монгол Улсын Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх

1.2. Ойн хүрээнд зохион байгуулагдах хурдан морины уралдааныг Засгийн газрын тогтоолоор батлагдах бүсийн уралдаан болгон хамтатган зохион байгуулах асуудлыг холбогдох газарт уламжлах

1.3. Ойг тэмдэглэх бэлтгэл ажлыг хангах нарийвчилсан төлөвлөгөө гарган биелэлтийг зохион байгуулж ажиллах

0121358

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Э.ӨНХБАТ

